



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Хүн, малын гоц халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1064 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дорнод, Хөвсгөл аймагт гарсан байгалийн голомтот хүн, мал, амьтны гоц халдварт өвчний халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд замын цагдаагийн хяналтын постыг түшиглэн мэргэжлийн байгууллагуудын ажилтнаас бүрдсэн хөдөлгөөнт хяналт шалгалтын ажлыг 24 цагаар зохион байгуулж ажиллуулахыг Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т болон өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц) нарт тус тус үүрэг болгосугай.

2.“Хөдөлгөөнт эргүүл”-ийн бүрэлдэхүүн маршрутыг нэгдүгээр, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 1,983,000 (нэг сая есөн зуун наян гурван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2025 он ажил/захирамж

1225010927

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн
А/193 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН БАТАЛГААТ БУС
АВТО ЗАМД “ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, МАРШРУТ

№	“Хяналт шалгалт явуулах ажлын хэсэг”-үүдийн байршил	Удирдан зохион байгуулах байгууллага	Хамтран ажиллах	Хугацаа
1.	Багахангай дүүргийн нутаг дэвсгэрийн баталгаат бус авто зам (алсын худаг, 5-н гүүр, үйлдвэрийн бүс, хээхрийн хоолой)	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой комисс	Онцгой байдлын хэлтэс-1, Цагдаагийн хэлтэс-1	IX/15-X/15

Тайлбар: Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой комисс нь нутаг дэвсгэрийнхээ авто техникийн шалган бүртгэх товчоон дээр ажиллаж байгаа болон хөдөлгөөнт эргүүлийн хяналт шалгалт явуулах ажлын хэсгийн үүрэг гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Хөдөлгөөнт эргүүлээр ажиллах тусгай чиг үүргийн байгууллагын алба хаагчид дүүргийн онцгой байдлын хэлтсийн шуурхай албаны автомашинтайгаар эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
А/193 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Хэдэн удаа	Нийт	Бүгд үнэ
1.	Хоол	20,000	Хүн	2/30	40,000	1,200,000
2.	A-92	2610	Литр	10/30	300	783,000
Нийт						1,983,000